



Гүйцэтгэлийн аудитын тайлан

АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

ᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠨ



**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНД ТАВИХ
ХЯНАЛТГҮЙГЭЭС ЧАНАР МУУТАЙ ХӨРӨНГӨ БИЙ БОЛЖ, ТӨСВИЙН
ХӨРӨНГӨ ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛАГДАХ ҮНДЭСЛЭЛ БОЛЖ БАЙНА**



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товьёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5

БҮЛЭГ 1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦҮҮЛЭН ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨСӨН ЭСЭХ	6
--	---

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ ОРОН НУТГИЙН НЭГДСЭН БОДЛОГО ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ НИЙЦЭЭГҮЙ, ТӨСӨВ, ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛГҮЙ БАТАЛЖ ХЭРЭГЖҮҮЛДЭГ ЗӨРЧИЛ АРИЛААГҮЙ БАЙНА.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЭСЭХ	8
--	---

ӨМНӨХ ОНД ДУУСААГҮЙ АЖЛЫН 38.5 ХУВЬ БУЮУ 5 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ОДООГООР ХЭРЭГЖЭЭГҮЙ ОН ДАМЖСАН, ТАЙЛАНТ ОНЫ АЖЛЫН 8 ХУВЬ БУЮУ 1 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖЭЭГҮЙ, ХЯНАЛТ ҮР ДҮНГҮЙГЭЭС ЧАНАР БАЙДАЛ МУУ БАЙНА.

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН, ҮР АШИГТЭЙ ЭСЭХ	13
---	----

ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ОН ДАМНАН ХИЙГДДЭГ, ЧАНАР БАЙДАЛ МУУГААС ИРГЭД ОЛОН НИЙТЭД ҮР ӨГӨӨЖӨӨ ӨГӨХГҮЙ БАЙНА.

ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ :	17
ШИЙДВЭР:.....	23
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:.....	24
САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:.....	26
ХАВСРАЛТУУД:	33-38



Товчилсон үгсийн тайлбар

ИТХ	Иргэдийн Төлөөлөгчийн Хурал
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХАА	Худалдан авах ажиллагаа
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗД	Засаг дарга
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТАХ	Төсөл арга хэмжээ
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗД	Засаг дарга
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн Захирагч
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ОБГ	Онцгой байдлын газар



Хүснэгт, дүрслэл, , хавсралтын тайлбар

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан ТАХ /чиглэл тус бүрээр/	9
Дүрслэл 1	Хэрэгжүүлсэн ТАХ, үүнээс аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдаагүй ТАХ	8
Дүрслэл 2	Тайлант онд хэрэгжсэн ТАХ-ны гэрээний санхүүжилт, гүйцэтгэл /хувиар	10
Дүрслэл 3	Өмнөх онд хэрэгжсэн ТАХ-ны гэрээний санхүүжилт, гүйцэтгэл /хувиар	12
Дүрслэл 4	ТАХ-ны гэрээний санхүүжилт, гүйцэтгэл /хувиар/	16
Дүрслэл 5	ОНТХО-ын сүүлийн 5 жилийн хөрөнгийн зарцуулалт	16
Зураг 1	"Ёслол хүндэтгэлийн өргөө"	12
Зураг 2	"Цахиур төмөр" түүхэн дурсгалын цогцолбор	13
Зураг 3	Автозамын туузан гэрэлтүүлгийн ажил	13
Зураг 4	Бумбат даваа ХХК гүйцэтгэсэн автозамын нөхцөл байдал //Баяншанд, Баянхайрхан баг/	15
Зураг 5	Хөхморьт сумын жишиг гудамж	16
Зураг 6	Шарга сумын жишиг гудамж	16
Зураг 7	Замын хөнөөсний ажил	17
Зураг 8	Хүүхдийн хийлдэг тоглоом	17
Зураг 9	Соёл амралтын хүрээлэнгийн ариун цэврийн байгууламж	18
Хавсралт 1	Тайлант 2020 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний төлөвлөлтийн дэлгэрэнгүй судалгаа	
Хавсралт 2	Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны судалгаа	
Хавсралт 3	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилт, санхүүжилтийн судалгаа	
Хавсралт 4	Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу тооцсон алдангийн судалгаа	
Хавсралт 5	Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу тооцсон алдангийн судалгаа	
Хавсралт 6	Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгасан талаар	



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдэв, Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.
Аудитын зорилт	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд аудит хийж, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүн, үр ашигтай эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, аймаг болон сумдын ЗДТГ, бусад холбогдох байгууллага, хуулийн этгээд хамруулан гүйцэтгэлээ. Аудитын хугацаанд короновируст халдварын цар тахлын нөхцөл байдлын улмаас сумдад хийгдсэн ажлыг бодитоор үзээгүй болно.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит.Тулгуур зарчим” MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим арга зүйд нийцүүлэн аудит хийх журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон ажилтнуудын нийгмийн асуудал шийдвэрлэсэн байдал, тэтгэмж тусламж олголт, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материал, статистик судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, Тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдан зохион байгуулж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг явцын хяналт тавьж стандартыг хангуулан, ахлах аудитор Д.Цэрэнханд, аудитор Ц.Сайханжаргал, Б.Цэвэлмаа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ. Аудитын төлөвлөгөөг 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн дотор боловсруулан, талбарын ажлыг 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдөр хүртэл гүйцэтгэж,



Хүндрэл бэрхшээл

аудитын тайлан, судалгааг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн.

1. Дэлхий нийтэд тархсан шинэ төрлийн Ковид-19 цар тахал манай аймагт 04 дүгээр сард бүртгэгдэн, эрчимтэй тархаж хатуу хөл хорио тогтоосон энэ үед хамрагдагч байгууллагаас баримт материал авахад хүндрэлтэй байсан.
2. Орон нутгийн хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн солигдсоноос аудитад баримт материал бүрэн хамруулаагүй болно.
3. Автозам хариуцсан мэргэжлийн албан тушаалтан байхгүй тул авто замтай холбоотой асуудлыг үзэхэд хүндрэлтэй байлаа.

Үндсэн мэдээлэл

"Төсвийн хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 08 дугаар тогтоолоор 497.7 сая төгрөгийн 9 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 954.07 сая төгрөгийн санхүүжилтийг 12 ТАХ-нд зарцуулсан байна. Эдгээрээс 3 нь он дамжин хэрэгжсэн ТАХ, 9 нь шинээр хэрэгжиж байгаа ТАХ байна.

Мөн өмнөх онд хэрэгжсэн бөгөөд дуусаагүй 13 ТАХ-ээс 8 ТАХ-г хүлээн авсан, 5 ТАХ дуусаагүй чанар байдал муутайгаас хүлээн аваагүй байна.



БҮЛЭГ 1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ ОРОН НУТГИЙН НЭГДСЭН БОДЛОГО ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ НИЙЦЭЭГҮЙ, ТӨСӨВ, ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛГҮЙ БАТАЛЖ ХЭРЭГЖҮҮЛДЭГ ЗӨРЧИЛ АРИЛААГҮЙ БАЙНА.

1.1 Төсөл арга хэмжээг аймгийн хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулах шаардлагатай байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 20 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар ОНТХО-аар 420.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд 2020 оны 09 дүгээр сарын 28 өдрийн 8 дугаар тогтоолоор 497.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 хөрөнгө оруулалт ТАХ-г санхүүжүүлэхээр тодотгон хавсралтаар баталсан байна.

Харин авто зам, гүүрний байгууламжийн хөрөнгө оруулалтын ажлыг ТАХ тус бүрээр нэр байршлыг зааж баталж өгөөгүй бөөн дүнгээр 310.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ. Энэ нь Сангийн сайдын 2016 оны 415 дүгээр тушаалын 3 дугаар зүйлийн 3.1¹ дэх заалтыг зөрчсөн байна. Он дамжин хэрэгжиж байгаа дараах ТАХ-г санхүүжүүлэхээр баталсан байна. Үүнд:

- ✓ ТАХ-ээс Сумын төвд жишиг гудамж бий болгож, тохижуулах ажил багц-2, 7 /Хөхморьт, Баян-Уул/ гэсэн ТАХ-үүд нь он дамжин хийгдэн 2019 онд хүлээн авсан бөгөөд дутуу олгосон санхүүжилт 44.5 сая төгрөгийг 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 133/ШШ2020/00409 Шүүхийн шийдвэрээр олгосон байна.
- ✓ "Цахиур төмөр" түүхэн дурсгалын цогцолбор байгуулах ажил он дамжин хэрэгжиж байгаа бөгөөд тайлант онд хүлээн авсан байна.


Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын хавсралтаар "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ыг баталсан байна. Журмын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, тухайн санхүүгийн жилийн төсөлд тусгахдаа дараах зарчмыг баримтлахаар байна. Тухайлбал:

- ✓ Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон тухайн бүс нутгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан байх
- ✓ Салбарын хөгжлийн бодлого, салбарын болон бүс нутгийн дунд хугацааны стратеги, мастер төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэх ач холбогдолтой хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ байх
- ✓ Аймгийн ИТХ-ын шийдвэр бүхий орон нутагт хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээ байх

Гэвч бодит байдал дээр Нийгэм, эдийн засгийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй 5 ТАХ-г ИТХ-аас баталсан байна.

Дүрслэл №1: Хэрэгжүүлсэн ТАХ, үүнээс Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдаагүй ТАХ /өмнөх онтой харьцуулсан/

¹ ТЕЗ, аймаг, нийслэл төвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, тухайн санхүүгийн жилийн төсөлд тусгахдаа дараах зарчмыг баримтална



ОНТХО-оор 2020 онд хэрэгжүүлэхээр батлагдсан 10 ТАХ-ний 5 ТАХ буюу 42%-ийг "Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл", Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцээгүй ажлыг төлөвлөжээ. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 26.6 хувиар өссөн байна.

Эдгээр нийцээгүй ТАХ-г аймгийн ЗДТГ-аас оруулж батлуулсан эсэх, ИТХ-аас шууд баталсан эсэхийг тооцох боломжгүй байлаа.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.4 дэх заалтын дагуу хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний талаарх саналыг авч нэгтгэсэн баримтыг удаа дараа шаардсан боловч аудитад хамруулаагүй болно.

1.2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шаардлага хангасан төсөл арга хэмжээг батлах шаардлагатай байна.

Аймгийн ИТХ-аар ОНТХО-ын төсвийн төслийг ИТХ-аар хэлэлцэхдээ Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийгмийн эдийн засгийн 2020 оны үндсэн чиглэлд тусгагдаагүй 5 ТАХ-г баталсан.

ОНТХО-аар шинээр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөж, аймгийн ИТХ-д өргөн барихдаа төсөвгүй, техникийн нөхцөл гаргаагүй, нэр, хэрэгжих хугацаа, байршил тодорхойгүй, хөрөнгө оруулалтын бус шинжтэй, тухайн шатны төсвийн санхүүжилтийг хэрэгжүүлээгүй нийт 212.5 сая төгрөгийн 3 ТАХ-г төлөвлөж баталсан нь эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг нарийвчлан судалж тооцоогүй аймгийн Засаг дарга, ЗДТГ, түүний харьяа хэлтэс, аймгийн ИТХ-ын удирдлагуудын буруутай үйл ажиллагааг илэрхийлж байна. /Хавсралт-1/

1.2.1. ТАХ-г хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлсэн талаарх баримт материалыг хамруулаагүй.

Төсвийн тухай хууль болон Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журамд зааснаар аймгийн ТЕЗ нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлэхдээ орон нутгийн хэрэгцээ, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг нь тооцон эрэмбэлсэн байх шаардлагатай.

Аймгийн ОНТХО-аар 2020 онд хийгдэх ажлын саналыг иргэдээс авч нэгтгэсэн гэх боловч баримт материалыг хамруулаагүй. Иймд шалгуулагч этгээд нь төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1² дэх заалтад заасан үүргээ биелүүлээгүй гэж үзлээ.

Мөн хэрэгцээ, үр ашиг, ач холбогдлыг тооцсон тооцоо судалгаа, хэлэлцэн үнэлсэн хурлын тэмдэглэл, баталгаажуулсан баримт материал байхгүй байлаа. Өмнөх онуудад эрэмбэлэх ажил хангалтгүй хийгдэж байгаа талаар тайланд тусган, зөвлөмж, албан шаардлага хүргүүлж байсан ч зөрчлийг давтан гаргасаар байна. Энэ нь хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг зөв үнэлээгүй, үр ашгийг тооцоогүй төсөл арга хэмжээ төсөвт тусгагдан батлагдах нөхцөл байдлыг үүсгэж байна.

² төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах



1.2.2. Хэрэгжүүлсэн ТАХ-ны 30 хувь нь төсөв, ТЭЗҮ-гүй, 1 ТАХ техникийн нөхцөл гаргуулаагүй байна.

Тухайн санхүүгийн жилд эхлүүлэхээр төлөвлөж буй барилга байгууламж нь дээрх зарчмыг баримталсан байхын зэрэгцээ инженер хайгуулын судалгаа хийж, дүгнэлт гаргасан, төслийг магадлалаар батлуулсан, барилга барих газар болон инженерийн шугам, сүлжээний асуудлыг бүрэн шийдсэн, үр ашигтай нь техник, эдийн засгийн үндэслэл, тооцоогоор нотлогдсон зэрэг барилгын ажлыг эхлүүлэх нөхцөлийг хангасан, урсгал зардлын урьдчилсан тооцоо хийгдсэн байхаар байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөхдөө тухайн салбарын бодлого, чиглэлийн яам, мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг заавал тусгах бөгөөд шаардлагатай тохиолдолд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг тусгасан байвал зохино. Мөн их засварын ажлыг төлөвлөхдөө тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох материалыг үндэслэхээр байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4³ дэх заалтад хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгахаар байна. Гэтэл аймгийн ИТХ-д ажлын даалгавар, техникийн нөхцөл нь тодорхой болоогүй 2 ТАХ-ний 132.5 сая төгрөгийн төсвийг өргөн барьснаас тусдаа аймгийн ИТХ-аар төсөв хэлэлцэхдээ техник эдийн засгийн үндэслэл, төсвийн тооцоолол хийгдээгүй 1 ТАХ-ний 80.0 сая төгрөгийг нэмж баталжээ. /хавсралт -1/

Энэ нь Төсвийн тухай хуулийн 68.2./ Төсвийн төслийг ИТХ-р хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана./ гэж заасан боловч хэрэгжүүлээгүй байна.

1.2.3. Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ажлыг төлөвлөж батлуулаагүй байна.

Тайлант онд хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ-г төлөвлөгөөнд тусгаагүй байгаа нь сайшаалтай хэдий ч “Гэгээн нуур-цэвэр ус” ОНӨААТҮГ-т санхүүгийн дэмжлэг олгож энэ нь ажиллагсдын цалин, урсгал зардалд зарцуулагдсаар байна.

Хүснэгт 1: Хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан ТАХ /чиглэл тус бүрээр/

	Чиглэл	Тоо хэмжээ	Төсөвт өртөг /сая.төг/
1	Барилга байгууламж	1	80.0
2	Их засвар	3	96.0
3	Тоног төхөөрөмж	1	24.0
4	Дэмжлэг	1	215.5
5	Дэд бүтэц	5	374.0
6	Хөшөө, дурсгал	1	17.9
	Нийт дүн	12	763.4

1.2.4. Хөрөнгө оруулалтаар ТАХ-ний жагсаалтад нэр, хэрэгжих хугацаа, байршил тодорхой зааж батлуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийгмийн эдийн засгийн үндсэн чиглэлд тусгагдаагүй ТАХ-г эс тооцвол хэрэгжүүлэхээр баталсан ТАХ нь ТЭЗҮ, нэр, байршлыг тодорхой тусгаж төлөвлөж баталсан байна

³ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.



1.2.5. Хөрөнгө оруулалтаар тухайн шатны төсвийн санхүүжилт хэрэгжүүлэхээр 1 ТАХ-г төлөвлөж батлуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6 дахь заалтад “Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалтыг зөрчиж орон нутгийн төсвийн хөрөнгөөр улсын төсвийн 1 байгууллагад хөрөнгө оруулалт, их засвар, тоног төхөөрөмж худалдан авахад зориулж 24.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангах 1 ТАХ-г баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-д “Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

БҮЛЭГ 2. ӨМНӨХ ОНД ДУУСААГҮЙ АЖЛЫН 38.5 ХУВЬ БУЮУ 5 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ХЭРЭГЖЭЭГҮЙ ОН ДАМЖСАН, ТАЙЛАНТ ОНЫ АЖЛЫН 8 ХУВЬ БУЮУ 1 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖЭЭГҮЙ, ХЯНАЛТ ҮР ДҮНГҮЙГЭЭС ЧАНАР БАЙДАЛ МУУ БАЙНА.

2.1 Гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу хийгдсэн байна.

ТБОНӨХБАҮХАТХ-д заасны дагуу захиалагч буюу аймгийн Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.6⁴-д заасны дагуу 2020 оны орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний “Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө”-г баталсан байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хийгдэх ажлуудад тендер шалгаруулалтыг хийхдээ тендерийн урилгыг өдөр тутмын Зууны мэдээ сонин болон www.e-procurement.mof.gov.mn, www.govi-altai.gov.mn, www.meps.gov.mn веб сайтуудад тендерийн урилга болон баримт бичгүүдийг нийтэлж ажилласан байна. Мөн www.shilendans.gov.mn сайтад тендерт оролцсон оролцогчийн шалгарсан болон шалгараагүй шалтгаан тайлбарыг ТАХ тус бүрээр оруулж өгсөн байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэх ТАХ-ний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаар зохион байгуулах үнэлгээний хороодыг аймгийн Засаг даргын тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна. Үнэлгээний хороод Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалаар баталсан “Бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт бичиг”-ийг баримтлан боловсруулсан байна.

ОНТХО-аар 2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 745.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ-ээс ХАА зарлах шаардлагагүй буюу байгууллагуудад олгосон дэмжлэг тусламж 1 ТАХ, шууд худалдан гэрээ байгуулсан 2 ТАХ, тендер шалгаруулалтын онцгой журам буюу харьцуулалтын аргаар 5 ТАХ, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 1 ТАХ тус тус зохион байгуулжээ.

Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын 1.73, Сангийн сайдын 2013 оны 7 дугаар тушаалаар баталсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын 1.44-т заасны дагуу аймгийн Орон нутгийн өмчийн газар нь ТАХ-ний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахдаа цахим системийг ашигласан байна. /Хавсралт-2/

2.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь хангуулаагүй байна.

2.2.1 Тайлант онд хэрэгжсэн 1 ТАХ-г эс тооцвол ажлын гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжилтийг олгосон байна.

Аймгийн ИТХ-ын хурлын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 8 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралтаар төсөвт тодотгол хийж ОНТХО-ын төсвийг 497.7 сая

⁴ 31.1.6. худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх




төгрөгөөр, замын сангийн төсвийг 310.0 сая төгрөгөөр баталсан бөгөөд 3 ТАХ-ны 72.6 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу, 2 ТАХ-ны 3.2 сая төгрөгийн магадалшгүй ажлын санхүүжилт дутуу, 4 ТАХ-ны 1.5 сая төгрөгийн техник хяналтын зардал дутуу, 1 ТАХ-ны сая төгрөгийн зохиогчийн хяналтын зардлыг тус тус олгосон байна. /Хавсралт-3/

Тайлант оны ТАХ-ны санхүүжилт, гүйцэтгэлийн талаар:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6 дахь заалтад “Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалт, Монгол улсын Хилийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5-т “Улсын хил хамгаалах байгууллагын төсвийг улсын төсөвт тусган санхүүжүүлнэ” гэсэн заалтуудыг Алтай сумын Хилийн 0214-р ангид 24.0 сая төгрөгийн 24 мотоциклийн тусламж үзүүлсэн байна.

Иймд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй” гэж заасны дагуу цаашид Төсвийн тухай хууль, түүний зарчмуудыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Дүрслэл 2: Тайлант онд хэрэгжсэн ТАХ-ны гэрээний санхүүжилт, гүйцэтгэл /хувиар/



Доорх 3 ТАХ-г эс тооцвол гэрээний дагуу санхүүжилтийг бүрэн олгож, ажлын гүйцэтгэлийг хангуулан хүлээн авсан байна.


- Сумын төвд жишиг гудамж бий болгож, тохижуулах ажил багц 2-/ Баян-Уул сум/ ТАХ-ны гэрээний дүн 84.8 сая төгрөгөөс өмнөх онд 46.9 сая төгрөгийг, тайлант онд 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 133/ШШ2020/00409 Шүүхийн шийдвэрээр 10.2 сая төгрөгийг олгон, техник хяналтын зардалд 1.5 сая төгрөгийг шилжүүлж, үлдэгдэл 26.3 сая төгрөгийг олгоогүй байна. Уг ТАХ-г 2019 онд улсын комисс ажиллан хүлээн авсан боловч ажлаа дутуу гүйцэтгэсэн гэж үзэн бүртгэлд тусгаагүй маргаантай байна.
- Сумын төвд жишиг гудамж бий болгож, тохижуулах ажил багц-7/Хөхморьт сум/ ТАХ-ны гэрээний дүн 87.3 сая төгрөгөөс өмнөх онд 29.7 сая төгрөгийг, тайлант онд 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 133/ШШ2020/00409 Шүүхийн шийдвэрээр 29.7 сая төгрөгийг олгон, техник хяналтын зардалд 1.7 сая төгрөгийг шилжүүлж, үлдэгдэл 26.2 сая төгрөгийг олгоогүй байна. Уг ТАХ-г 2019 онд улсын комисс ажиллан хүлээн авсан байна.
- Соёл амралтын хүрээлэнд ёслол хүндэтгэлийн өргөө байгуулах ТАХ-ны гэрээний дүн 78.2 сая төгрөгөөс тайлант онд 54.5 сая төгрөгийг олгож, 23.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тус ТАХ-г "Содон ресурс" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 70 хувийн санхүүжилтээ авсан боловч бодит байдалд хэрэгжилт хангалтгүй байна.

Өмнөх оны ТАХ-ны дансны санхүүжилт, гүйцэтгэлийн талаар:



Тайлант хугацаанд 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Алтай хотоор дайран өнгөрч байгаа улсын чанартай авто замын гэрэлтүүлгийг туузан гэрлээр чимэглэх” ажилд гүйцэтгэгч “Алтайн хүрд” ХХК-ийн Төрийн банкны эскроу дансанд 80.0 сая төгрөгийг, 39.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Алтай хотод нийтийн бие засах газар байгуулах” ТАХ-д гүйцэтгэгч “Хайчийн нуруу” ХХК-ийн Төрийн банкны эскроу дансанд 39.8 сая төгрөгийг, 39.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүүхдийн паркийн тоглоомын тоог нэмэгдүүлэх” ТАХ-г гүйцэтгэгчийн Төрийн банкны эскроу дансанд 12.4 сая төгрөг, нийт 132.2 сая төгрөгийг байршуулсан байсныг гүйцэтгэгчид санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Дүрслэл 3: Өмнөх онд хэрэгжсэн хүлээн аваагүй ТАХ-ны гэрээний санхүүжилт, гүйцэтгэл /хувиар/



Доорх 4 ТАХ-г эс тооцвол гэрээний дагуу санхүүжилтийг бүрэн олгож, ажлын гүйцэтгэлийг хангуулан хүлээн авсан байна.

- “Ээж хайрхан констракшн” ХХК-ийн Алтай сумд гүйцэтгэсэн 90.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Жишиг гудамж”-ийн ажилд 66.0 сая төгрөг буюу 73 хувийн санхүүжилтийг олгосон, хүлээн аваагүй маргаантай байна.
- Иргэдийн бүлгийн гүйцэтгэх 19.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хүүхдийн паркийн тоглоомын тоог нэмэгдүүлэх ажлын санхүүжилтийг 100 хувь олгосон, ажлын гүйцэтгэл 0 хувьтай байна.
- Бигэр сумын 5-р багт хөв байгуулах 24.5 сая төгрөгийн өртөгтэй ТАХ-ны санхүүжилтийг 100 хувь олгосон, ажлын чанар муугаас хүлээн аваагүй байна.
- Дарив сумын Хужирт багийн төвийн барилгын дэмжлэгт 7.5 сая төгрөгийн дэмжлэгийг олгосон, гэрээний хугацаанд хүлээлгэж өгөөгүй.
- Алтай хотод 3.49 км хатуу хучилттай авто зам, явган зам, дугуйн зам барих ажил нь 2018 оноос он дамжин хэрэгжиж байгаа бөгөөд ажлын чанар байдал хангалтгүй байна.

2.2.2 Гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд ТАХ-г гүйцэтгээгүй бөгөөд захиалагч гэрээний хугацааг үндэслэлгүйгээр сунгасан байна.

Тайлант оны ажлын гүйцэтгэлийн талаар:

- ✚ Соёл амралтын хүрээлэнд ёслол хүндэтгэлийн өргөө байгуулах ТАХ-ны ажлын гүйцэтгэл 50 хувьтай гэрээний хугацаанд хүлээлгэн өгөх боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.



Зураг 1: "Ёслол хүндэтгэлийн өргөө"



- ✚ "Тус онд хэрэгжүүлсэн 1, 2 дугаар сургуулийн гал зуухны өрөөний засварын ажил" батлагдсан төсвөөс зөрүүтэй хийгдсэн байна. Тухайлбал: Лаборатори 1 дүгээр сургуулийн гал зуухны өрөөний нэг давхрын шал плита хийгдээгүй, 2 дугаар сургуулийн гал зуухны өрөөний хананы плита 1.8м өндөртэй хийгдсэн.
- ✚ "Алтай хотын теле хяналтын камерын системийн нэгдсэн засвар 5G цэвэрлэгээ үйлчилгээ"-ний ажлын хэрэгжилттэй танилцахад 2021 оны 05 дугаар сард болсон байгалийн гамшигт үзэгдлийн улмаас цэвэрлэсэн камер дахин бохирдсон, шилэн кабель тасарсан байна.
- ✚ Тус онд хэрэгжүүлсэн "Цахиур төмөр" түүхэн дурсгалын цогцолбор байгуулах ажилын чанар байдал муутай байна. Учир нь гэрэлтүүлэг эвдэрсэн, хөшөөний суурин хэсэгт гадна өнгөлгөө хуурсан, шатны чулуун хэсэг салсан байна.

Зураг 2: "Цахиур төмөр" түүхэн дурсгалын цогцолбор



Өмнөх онуудад хийгдэж дуусаагүй ТАХ-ны ажлын гүйцэтгэлийн талаар:

Өмнөх онуудаас шилжин ирсэн 13 ТАХ байгаагаас 8 ТАХ дуусаж тайлант онд хүлээн авсан, 5 ТАХ дуусаагүй байна. Үүнд: /[хавсралт №5](#)/

- "Ээж хайрхан констракшн" ХХК-ийн Алтай сумд гүйцэтгэсэн 90.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Жишиг гудамж"-ийн ажилд 66.0 сая төгрөгийн санхүүжилтийг ОНХС, ОНТХО-аас олгосон, ажлыг 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн дотор хүлээлгэн өгөхөөр гэрээнд заасан байтал гэрээнд сунгалт хийгдээгүй, өдийг хүртэл хүлээлгэн өгөөгүй тул ГХБХБГ-аас Баянгол дүүргийн Прокурорын газарт хандаад байна.
- Иргэдийн бүлгийн гүйцэтгэх 19.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хүүхдийн паркийн тоглоомын тоог нэмэгдүүлэх ажил огт хийгдээгүй байна



- Бигэр сумын 5-р багт хөв байгуулах 24.5 сая төгрөгийн өртөгтэй ТАХ-ны ажлын чанар муугаас хүлээн аваагүй байна.
- Дарив сумын Хужирт багийн төвийн барилгын дэмжлэгт 7.5 сая төгрөг олгосон бөгөөд ковид-19 цар тахалтай холбоотойгоор гэрээ сунгагдсан боловч гэрээний хугацаа дууссан ажлаа хүлээлгэн өгөөгүй байна.
- Алтай хотод 3.49 км хатуу хучилттай авто зам, явган зам, дугуйн зам барих ажил нь 2018 оноос он дамжин хэрэгжиж байгаа бөгөөд ажлын чанар муу, хангалтгүй байна.

“Есөнбулаг суманд хийгдсэн ТАХ-г газар дээр нь очиж үзэхэд дараах байдалтай байна.

- "Алтайн хүрд" ХХК-ний гүйцэтгэсэн 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Алтай хотоор дайран өнгөрч байгаа улсын чанартай автозамын гэрэлтүүлгийг туузан гэрлээр чимэглэх ажлын гүйцэтгэлтэй танилцахад туузан гэрэл зарим хэсгээрээ унжсан, асахгүй, гэрэлт самбар эвдэрсэн.

Зураг 3: Автозамын туузан гэрэлтүүлгийн ажил:



- "Хайчийн нуруу" ХХК-ний гүйцэтгэсэн 39.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Алтай хотод нийтийн бие засах газрын байгууламжаас 70 жилийн цэцэрлэгт хүрээлэнгийн ариун цэврийн байгууламжийн гадна хаалга түгжээ хийгдээгүй, цахилгааны утсыг далдлаагүй, эмэгтэй суултуур 1 ш суурилуулаагүй, гадна довжооны ирмэг хагарсан, дээврийн төмрийн хормой хэсэг унасан байна.
- Бумбат даваа ХХК-ний гүйцэтгэсэн Алтай хотод 3.49 км хатуу хучилттай авто зам, явган зам, дугуйн зам барих ажилтай танилцахад Баяншанд багийн авто зам хөндлөн цууралт үүсэж хагарсан, явган хүний зам зарим хэсэгтээ эвдэрч нурсан, Баянхайрхан багийн зам хагарсан, эвдрэл үүссэн байна.

Зураг 4: Бумбат даваа ХХК гүйцэтгэсэн автозамын нөхцөл байдал //Баяншанд, Баянхайрхан баг/





ТАХ-ний гэрээний хугацааг хэтрүүлсэнд тооцсон алдангийн талаар:

Тайлант он: Ковид-19 цар тахлыг гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэж үзэж тооцсон алдангид шийдвэр өгөөгүй болно. ОНТХО-р хийгдсэн ажлыг гэрээт хугацаанд хүлээлгэн өгсөн эсэхийг судалж үзэхэд 6 ТАХ-г гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөөгүй хугацаа хоцруулсанд нийт 39.0 сая төгрөгийн алданги тооцохоор байна. /Хавсралт-4/ Үүнд:

- ✚ Соёл амралтын хүрээлэнд ёслол хүндэтгэлийн өргөө байгуулах 80.0 сая төгрөгийн төсөвтэй ТАХ-ны тухайд ажлыг 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн хооронд хүлээлгэн өгөхөөр анх гэрээ байгуулсан. Гэрээг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл сунгасан байна. Гэвч 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар ажлын гүйцэтгэл хангалтгүй байна. Иймээс Захиалагч гүйцэтгэгчтэй байгуулсан 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн ГААОНӨГ/202001005 дугаартай гэрээний заалт, Тендерийн бичиг баримтын техникийн нөхцөлд хоног тутамд 0.3 хувийн алданги тооцох заалтын дагуу алдангийг тооцож төлүүлэхээр байна.
- ✚ Тус онд хэрэгжүүлсэн "Цахиур төмөр" түүхэн дурсгалын цогцолборын тухайд ажлыг 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдөр хүлээлгэн өгөхөөр гэрээнд заасан боловч 2020 оны 07 дугаар 09-ний өдөр буюу 38 хоногоор хэтрүүлэн хүлээлгэн өгсөнд гэрээнд заасны дагуу алданги тооцоход 1.1 сая төгрөгийг төлүүлэхээр байна.
- ✚ Лаборатори 1 дүгээр сургууль, Есөнбулаг сумын 2 дугаар сургуулийн гал тогооны их засварын ажлыг 2020 оны 03 дугаар сарын 18-нд хүлээлгэн өгөхөөр гэрээнд заасан боловч 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдөр буюу тус бүр 12 хоногоор хэтрүүлэн хүлээлгэн өгсөнд гэрээнд заасны дагуу 0.5 сая төгрөгийн алдангийг төлүүлэхээр байна.
- ✚ Хилийн цэргийн застав, харуулын постуудад 12 мотоцикл нийлүүлэх ТАХ-ны ажлыг 2020 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хүлээлгэн өгөхөөр гэрээнд заасан боловч 2020 оны 05 дугаар сарын 09-ний өдөр буюу тус бүр 19 хоногоор хэтрүүлэн хүлээлгэн өгсөнд гэрээнд заасны дагуу 2.3 сая төгрөгийн алдангийг төлүүлэхээр байна.
- ✚ Гэрлэн дохиотой гурван замын уулзвараас баруун тийш зогсоол хийх ТАХ-ны ажлыг 2020 оны 09 дүгээр сарын 14-ны өдөр хүлээлгэн өгөхөөр гэрээнд заасан боловч 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдөр буюу тус бүр 81 хоногоор хэтрүүлэн хүлээлгэн өгсөнд гэрээнд заасны дагуу 3.6 сая төгрөгийн алдангийг төлүүлэхээр байна.
- ✚ Цемент бетон зам тавих ТАХ-ны ажлыг 2020 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр хүлээлгэн өгөхөөр гэрээнд заасан боловч 2020 оны 12 дугаар сарын 26-ны өдөр буюу тус бүр 51 хоногоор хэтрүүлэн хүлээлгэн өгсөнд гэрээнд заасны дагуу 31.5 сая төгрөгийн алдангийг төлүүлэхээр байна.

Хөрөнгө оруулалтын ажлын баримтад ТАХ-ний гэрээт хугацааг хоцруулсан шалтгааныг нотлох баримт байхгүй, үе шатны хяналтад хугацаа хоцорсон талаар дурдаагүй байгаа бөгөөд энэ нь холбогдох албан тушаалтан гэрээнд заасан үүргийг хэрэгжүүлэхгүй байгаа хариуцлагагүй үйлдэлтэй холбоотой байна.

Өмнөх он: ОНТХО-р өмнөх онуудад хийгдсэн ажлыг гэрээт хугацаанд хүлээлгэн өгсөн эсэхийг судалж үзэхэд 4 ТАХ-г гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөөгүй хугацаа хоцруулсанд нийт 4.3 сая төгрөгийн алданги тооцохоор байна. /Хавсралт-5/ Үүнд:

- ✚ Алтай хотоор дайран өнгөрч байгаа улсын чанартай автозамын гэрэлтүүлгийг туузан гэрлээр чимэглэх 80.0 сая төгрөгийн төсөвтэй ТАХ-ны тухайд ажлыг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хооронд гүйцэтгэж хүлээлгэн өгөхөөр анх гэрээ байгуулсан. Гэвч 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдөр буюу 48 хоногоор хэтрүүлэн хүлээлгэн өгсөнд гэрээнд заасны дагуу 1.9 сая төгрөгийг төлүүлэхээр байна.
- ✚ Алтай хотод нийтийн бие засах газар байгуулах 39.8 сая төгрөгийн төсөвтэй ажлыг 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдөр хүлээлгэн өгөхөөр гэрээнд заасан боловч 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдөр буюу тус бүр 22 хоногоор хэтрүүлэн хүлээлгэн өгсөнд гэрээнд заасны дагуу 0.5 сая төгрөгийн алдангийг төлүүлэхээр байна.



- ✚ Хүүхдийн паркийн тоглоомын тоог нэмэгдүүлэх /Б.Дашрэнцэн ахлагчтай иргэдийн бүлэг/ 19.5 сая төгрөгийн төсөвтэй ажлыг 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр гэрээний хугацаа дууссан бөгөөд аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/561 дугаар захирамжаар гэрээг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдөр болгож сунгасан хэдий ч уг ажил өнөөдрийн байдлаар огт хийгдээгүй байна. Иймд гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу 1.9 сая төгрөгийг алдангийг тооцож төлүүлэхээр байна.
- ✚ Хүүхдийн паркийн тоглоомын тоог нэмэгдүүлэх /М.Одням ахлагчтай иргэдийн бүлэг/ 19.9 сая төгрөгийн төсөвтэй ажлыг 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр гэрээний хугацаа дууссан бөгөөд гэрээг 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр болгож сунгасан байна. Гүйцэтгэгч 2020 оны 07 дугаар сарын 06-ны 5 хоногоор хэтрүүлэн хүлээлгэн өгсөнд гэрээнд заасны дагуу 0.05 сая төгрөгийг төлүүлэхээр байна

2.3 Шат шатны хяналт ажлын хариуцлага сул байгаагаас өмнөх онуудад илэрсэн зөрчлүүдийг давтан гаргасаар байна.

2.3.1 Төсөл арга хэмжээнд тавих захиалагч хяналт сул байгаагаас ажлын чанар муу, ашиглалт хангалтгүй байна.

Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын ТАХ-ний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцахаар байна.

Аймгийн ОНТХО-ийн хөрөнгөөр хийгдсэн ТАХ-нд аймгийн ГХБХБГ-аас гэрээний дагуу захиалагчийн хяналтыг хийхээр байна. Аудитаар захиалагчийн хяналт хийсэн баримт материал ирүүлж байгаа хэдий ч бодит байдал дээр хяналт үр нөлөөгүй, үр дүнгүй байгаа нь доорх үйл ажиллагаанаас харагдаж байна.

- 2015-2020 онд хэрэгжсэн 1,685.6 сая төгрөгийн өртөгтэй 19 ТАХ-ны ашиглалт хангалтгүй, чанар байдал муу, 61.0 сая төгрөгийн өртөгтэй 3 ТАХ-г Прокурорт шилжүүлсэн.
- ОНТХО-ын аудитыг жил бүр гүйцэтгэдэг бөгөөд сүүлийн 3 жилийн зөрчлийг нэгтгэж харвал жил бүр өссөн байна.



Дүрслэл 4: ОНТХО-аар сүүлийн 3 жилд илэрсэн зөрчил /сая.төг/

2.3.2 Дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2020 оны ОНХО-ын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж үнэлэлт дүгнэлт өгөөгүй байна. Хөрөнгө оруулалтын ТАХ-ны хэрэгжилт явцын байдалд ТЕЗ-ийн дэргэдэх дотоод хяналтыг зайлшгүй ажиллуулах шаардлагатай байгаа нь дээр гарсан зөрчлөөс харагдаж байна.

2.3.3 Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн газраас ТАХ-нд хяналт хийсэн нотлох баримтгүй, шат шатны ажлын хариуцлага сул байна.

Аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс явц бүрд хяналт тавьж ажилласан гэх боловч, бодит байдал дээр хяналт шалгалт хийсэн эсэхийг нотлох хурлын тэмдэглэл, үүрэг даалгавар өгсөн нотлох баримтгүй байгаа нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын 5.2⁵ дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй

⁵ захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллана



болохыг харуулж байна. Өөрөөр хэлбэл захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа ГХБХБГ-ыг мэргэжил арга зүйн бодлогоор хангах, түүнд хяналт тавих шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНД ХИЙГДДЭГГҮЙ, ЧАНАР БАЙДАЛ МУУГААС ИРГЭД, ОЛОН НИЙТЭД ҮР ӨГӨӨЖӨӨ ӨГӨХГҮЙ БАЙНА.

3.1 Тайлант онд хэрэгжсэн ТАХ-ны 16 хувийг данс бүртгэлд тусгаагүй, 40 хувийг ашиглаагүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр өмнөх оноос шилжин ирсэн 13 ТАХ болон тайлант онд хэрэгжсэн 12 ТАХ нийт 25 ТАХ-г данс бүртгэлд тусгасан эсэхийг тулган баталгаажуулахад 809.2 сая төгрөгийн 14 ТАХ-г НББ-д тусгасан, 215.5 сая төгрөгийн 1 ТАХ-г НББ-д тусгах шаардлагагүй /дэмжлэг/, 144.5 сая төгрөгийн 6 ТАХ ажил дуусаагүй чанаргүй хийгдсэн хүлээн аваагүй, 146.2 сая төгрөгийн 4 ТАХ-г данс бүртгэлд тусгаагүй байна. /хавсралт №6/

ТАХ-г хүлээн авах комиссын үйл ажиллагаанд дараах асуудлууд байна. Үүнд:

- ✚ "Тус онд хэрэгжүүлсэн 1, 2 дугаар сургуулийн гал зуухны өрөөний засварын ажил"-ын ашиглалтад авах комиссын дүгнэлтэд гишүүд /Архивын тасаг, ОБГ/ гарын үсэг зураагүй, хүлээн аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, данс бүртгэлд тусгасан байна.
- ✚ Тус онд хэрэгжүүлсэн "1, 2 дугаар сургуулийн гал зуухны өрөөний засвар" ТАХ-г хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд захиалагчийн төлөөллийг оруулаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралт "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралтын 4 дэх заалт "Барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн:- Захиалагчийн төлөөлөл" -ыг зөрчсөн байна.

3.2 Орон төсвийн хөрөнгө оруулалт тухайн жилд хүрэх зорилтот түвшнийг хангаж, түүний үр ашгийг тооцож байгаа эсэхийг нотлох боломжгүй баримт материал ирүүлээгүй.

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын хавсралтаар "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ыг баталсан байна. Журмын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, тухайн санхүүгийн жилийн төсөлд тусгахдаа дараах зарчмыг баримтлахаар байна. Тухайлбал:

- ✓ Шинээр баригдах барилга байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, батлагдсан төсөв, үр ашгийн тооцоо, нийгмийн шинж чанартай барилга байгууламжийн хувьд түүнийг барих зайлшгүй хэрэгцээ, шаардлага, судалгаа, тооцоо, батлагдсан төсвийг үндэслэх

Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 295 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам ба аргачлал" нь 2020 оноос мөрдөгдөж байна. Гэвч хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх түвшин, түүний үр ашгийг тооцсон баримт материалыг ирүүлээгүйгээс нотлох боломжгүй байлаа.


3.3 Сүүлийн 5 жилд ОНТХО-аар хийгдсэн ТАХ-ын 17 хувь буюу 1.745.1 сая төгрөгийн ажил чанал муу, ашиглалт хангалтгүй иргэд олон нийтэд үр өгөөжөө өгөөгүй байна.

ОНТХО-аар 2015-2019 онд 10,140.4 сая төгрөгийн 161 ТАХ-г санхүүжүүлснээс 54%-ийг авто зам, гэрэлтүүлгийн ажилд, 20%-ийг барилга байгууламж, хөрөнгө оруулалтад, 10%-ийг санхүүгийн дэмжлэгт, 8%-ийг техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдаж авахад, 8%-ийг урсгал засвар, зээл, зураг төсөв боловсруулах ажилд зарцуулжээ. Нөгөө талаас эд хогшил, бараа материал худалдан авах болон урсгал засварын зардал, санхүүгийн



дэмжлэгийг орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган, хэрэгжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын мөн чанар, үр өгөөжийг бууруулж байна. /Хавсралт №7 /

Дүрслэл 5: ОНТХО-ын 5 жилийн хөрөнгийн зарцуулалт



Сүүлийн 5 жилд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлуудаас 1,745.1 сая төгрөгийн өртөгтэй 17 ТАХ буюу нийт хэрэгжсэн ТАХ-ны 17 хувь нь ашиглалт хангалтгүй, ажил чанар байдал муу, 1 ТАХ-нд 25.0 сая төгрөгийн өөр эх үүсвэрээс урсгал засвар хийсэн байна. Тухайлбал:

- ОНТХО-аас 2017 онд Бигэр сумын Өөшний услалтын систем барих төсвийн ажилд 9.0 сая төгрөгийн санхүүжилт олгож

хийлгэсэн боловч өдийг хүртэл энэ услалтын систем хийгдээгүй байна.

- ОНТХО-аас 2016 онд Есөнбулаг сумд туузан гэрэлтүүлэг хийхэд 14.4 сая төгрөгийн, 2017 онд Есөнбулаг сумын гэр хорооллын хашааны өнгө үзэмжийг сэргээн засварлахад 10.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон ажлыг чанар байдал хангалтгүй, үр өгөөж багатай ажил болжээ.
- “Хасагтын гоёл” ХХК-ний гүйцэтгэсэн Хөхморьт сумын жишиг гудамжны /2018 онд ОНТХО-аас 26.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон/ засмал замын хайрга гарч ирсэн, явган хүний зам муруй, хагарал үүсэж овойсон, “Модон чөлөө” ХХК-ний гүйцэтгэсэн Цогт сумын жишиг гудамжны /2018-2019 онд ОНТХО-аас 54.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон/, чанар байдал хангалтгүй, “Айргийн хад” ХХК-ний гүйцэтгэсэн Шарга сумын жишиг гудамжны /2018-2019 онд ОНТХО-аас 57.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон/ замын нэг хэсэг хуурч хайрга нь гарсан байдалтай



Зураг 5: Хөхморьт сумын жишиг гудамж




Зураг 6: Шарга сумын жишиг гудамж

- ОНТХО-аар 2017 онд багийн засаг дарга нарыг унаажуулах ТАХ-нд 48.8 сая төгрөгийн мотоцикл худалдаж авснаас Алтай, Цогт, Шарга, Төгрөг, Тайшир сумдынх эвдэрсэн, 2018 онд Мэргэжлийн хяналтын газар худалдаж авсан фургон автомашинд 3.1 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл авч тавьсан, 2019 онд 3.6 сая төгрөгөөр худалдан авсан Есөнбулаг сумын багийн засаг дарга нарын мотоцикл эвдэрсэн, Шарга сумын ЗДТГ-ын УАЗ автомашины кроп эвдэрсний улмаас ашиглалтгүй байна.
- ОНТХО-аас 2018 онд 38.6 сая төгрөг, 2019 онд 53.1 сая төгрөгийн хөрөнгийг Алтай хотын хатуу хучилттай автозамын нөхөөс хийх ТАХ-нд зарцуулсан хэдий ч өнөөдрийн байдлаар нөхөөс хийгдсэн замууд дараах байдалтай байна.



Зураг 7: Замын нөхөөсний ажил



- “Ээж хайрхан констракшн” ХХК-ийн Алтай сумд гүйцэтгэсэн 90.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Жишиг гудамж”-ийн ажилд 66.0 сая төгрөгийн санхүүжилтийг ОНХС, ОНТХО-аас олгосон, ажлыг 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн дотор хүлээлгэн өгөхөөр гэрээнд заасан байтал гэрээнд сунгалт хийгдээгүй, өдийг хүртэл хүлээлгэн өгөөгүй тул ГХБХБГ-аас Баянгол дүүргийн Прокурорын газарт хандаад байна.

2019-2020 онд хийгдсэн ашиглалтгүй /хийгдээгүй/, чанар муу ТАХ:

- Алтай хотын теле хяналтын камерын системийн нэгдсэн засвар, цэвэрлэгээ үйлчилгээ хийх ТАХ-нд 2020 онд 20.0 сая төгрөгийн зарцуулсан хэдий ч аймгийн хэмжээнд энэ оны эхний 6 сарын байдлаар бүртгэгдсэн гэмт хэрэг 20 хувиар өсжээ. (Эх сурвалж: www.1212.mn)
- ОНТХО-ийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлж “Хүүхдийн паркийн тоглоомын тоог нэмэгдүүлэх” ТАХ-ний хүрээнд авсан 5.0 сая төгрөгийн өртөгтэй хүүхдийн хийлдэг тоглоом Есөнбулаг сумын ЗДТГ-ын нэр дээр бүртгэлтэй байх боловч Сум дундын ойн ангийн агуулахад ашиглалтгүй хадгалагдаж байгаа, хүүхдийн сагсан бөмбөгийн талбайн шийд эвдэрсэн байдалтай байна.

Зураг 8 : Хүүхдийн хийлдэг тоглоом, сагсан бөмбөгийн самбар



- “Алтай хотод нийтийн бие засах газар байгуулах” ТАХ-ний хүрээнд 2019 онд хийгдсэн 32.5 сая төгрөгийн Соёл амралтын хүрээлэн, 70 жилийн цэцэрлэгт хүрээлэнгийн байгууламжийг огт ашиглаагүй, цоожтой, сантехникийн холболтыг салгасан, цахилгааны утсыг далдлаагүй байдалтай байна.



Зураг 9 :Соёл амралтын хүрээлэн, 70 жилийн ойн цэцэрлэгт хүрээлэнгийн ариун цэврийн байгууламж



- “Энх-Өргөө” ХХК-ийн гүйцэтгэхээр гэрээ байгуулсан Бигэр сумын 5 дугаар багт хөв байгуулах ажилд 2019 онд 17.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон, ажил гэрээнд тавьсан шаардлагыг хангаагүй, дутуу хийгдэж захиалагчийн зүгээс хугацаатай албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлээгүй тул ГХБХБГ-аас аймгийн Прокурорын газарт хандсан байна. .
- Иргэдийн бүлгийн гүйцэтгэх 19.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хүүхдийн паркийн тоглоомын тоог нэмэгдүүлэх ажил огт хийгдээгүй байна
- Бигэр сумын 5-р багт хөв байгуулах 24.5 сая төгрөгийн өртөгтэй ТАХ-ны ажлын чанар муугаас хүлээн аваагүй байна.
- Дарив сумын Хужирт багийн төвийн барилгын дэмжлэгт 7.5 сая төгрөг олгосон бөгөөд гэрээт хугацаанд хүлээлгэн өгөөгүй байна.
- Алтай хотод 3.49 км хатуу хучилттай авто зам, явган зам, дугуйн зам барих ажил нь 2018 оноос он дамжин хэрэгжиж байгаа бөгөөд ажлын чанар муу, хангалтгүй байна.
- "Алтайн хүрд" ХХК-ний гүйцэтгэсэн 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Алтай хотоор дайран өнгөрч байгаа улсын чанартай автозамын гэрэлтүүлгийг туузан гэрлээр чимэглэх ажлын гүйцэтгэлтэй танилцахад туузан гэрэл зарим хэсгээрээ унжсан, асахгүй, гэрэлт самбар эвдэрсэн.

Ашиглалтад орсон зарим төсөл, арга хэмжээг бүрэн хүчин чадлаар нь ашиглахгүй, эвдрэл гэмтэл үүсэж байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүн, үр өгөөжийг бууруулж байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар:

Тус онд автозамын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 2 төсөл арга хэмжээний мэдээллийг шилэн дансны цахим хуудаст мэдээлээгүй байна.

ОНТХО, Автозамын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 12 төсөл арга хэмжээг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжүүд нь е-баримт гаргаж өгөөгүй, гүйлгээ хийсэн байна.

Өмнөх аудитын шийдвэрийн талаар:

Өмнөх аудитын шийдвэрээс 164.1 сая төгрөгийн төлбөрийн актыг төлүүлээгүй байна. Үүнд:

- ✓ “Орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар Алтай, Баян-Уул, Бигэр, Тайшир, Жаргалан, Хөхморьт, Цогт, Шарга сумдын “Жишиг гудамж” ТАХ-ний гэрээний хугацаа дууссан байхад хүлээлгэн өгөөгүйд тогтоосон 155.4 сая төгрөгийн алданги,
- ✓ “Орон нутгийн замын сангийн 2012-2014 оны хөрөнгө оруулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар “Заавар” ХХК-ийн 2013 онд “Алтай хотын хатуу хучилттай төв замуудад хурд сааруулагч хийх” ТАХ-д гэрээний дагуу тогтоосон 8.0 сая төгрөгийн акт байна.

Говь-Алтай аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны Шүүхийн 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 133/ШШ2019/00386 дугаар бүхий шийдвэрээр Жаргалан сумд жишиг гудамж байгуулах ГАОНӨГ/201801005 багц-5 дугаартай гэрээний үлдэгдэл



23.6 сая төгрөгийг “Өнө-Алтай” ХХК-д олгохыг удирдлага болгон тогтоосон байна. Бусад ТАХ-ын хувьд Шүүхийн шийдвэр гараагүй байна.

Орон нутгийн замын санд хийсэн аудитаар тогтоосон актыг төлүүлж биелэлтийг ирүүлэхийг аймгийн Засаг дарга нарт 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 305 дугаар, 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 54 дугаар, 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 504 дугаар албан тоотоор удаа дараа хүргүүлж байсан боловч шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна.

Өмнөх онуудад илэрч байсан зөрчил 2020 оны хөрөнгө оруулалтаар давтан гарч байгаа нь илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар аймгийн ИТХ, Засаг дарга болон харьяа байгууллага, холбогдох ажилтнуудын ажлын хариуцлага маш муу байгааг харуулж байна.

ИЛРҮҮЛЭЛТ:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн талаар:

1. "Соёл амралтын хүрээлэнд ёслол хүндэтгэлийн өргөө байгуулах" төсөл арга хэмжээг төсөвгүй байхад ИТХ-аар баталсан байна.
2. Аймгийн ЗД-ын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдаагүй 5 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан.
3. Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Гэрлэн дохиотой гурван замын уулзвараас баруун тийш зогсоол хийх", "Цемент бетон зам тавих ажил"-ыг төлөвлөхдөө төсөлгүй, гүйцэтгэгч компанийн зургийн дагуу гүйцэтгэсэн байна.
4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хууль тогтоомжид нийцсэн эсэхийг тодорхойлох боломжгүй, төлөвлөлтийн шатны баримтыг аудитад хамруулаагүй

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ны хэрэгжилтийн талаар:

5. "Соёл амралтын хүрээлэнд ёслол хүндэтгэлийн өргөө байгуулах" төсөл арга хэмжээг "Содон ресурс" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 70 хувийн санхүүжилтээ авсан боловч бодит байдалд хэрэгжилт хангалтгүй, гэрээний хугацаанд хүлээлгэн өгөх боломжгүй нөхцөл үүссэн байна.
6. "Тус онд хэрэгжүүлсэн 1, 2 дугаар сургуулийн гал зуухны өрөөний засварын ажил"- батлагдсан төсвөөс зөрүүтэй хийгдсэн байна.
7. Тус онд хэрэгжүүлсэн "Цахиур төмөр" түүхэн дурсгалын цогцолбор байгуулах ажил-ын чанар байдал муутай байна.
8. "Тус онд хэрэгжүүлсэн 1, 2 дугаар сургуулийн гал зуухны өрөөний засварын ажил"-ын ашиглалтад авах комиссын дүгнэлтэд гишүүд /Архивын тасаг, ОБГ/ гарын үсэг зураагүй, хүлээн аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, данс бүртгэлд тусгасан байна.
9. Тус онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг хүлээн авах комисст захиалагч төлөөлөл оруулаагүй байна. Тухайлбал: 1, 2 дугаар сургуулийн гал зуухны өрөөний засвар/
10. Сумын төвд жишиг гудамж бий болгож, тохижуулах ажил багц-2 /Баян-Уул/-ыг 2019 онд комисс хүлээн авсан байх боловч ашиглагч талаас ажлаа дутуу гүйцэтгэсэн гэж үзэн бүртгэлд тусгаагүй маргаантай байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-нд хийсэн хяналтын талаар:

11. Тус онд автозамын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 2 төсөл арга хэмжээний мэдээллийг шилэн дансны цахим хуудаст мэдээлээгүй байна.
12. ОНТХО, Автозамын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 12 төсөл арга хэмжээг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжүүд нь е-баримт гаргаж өгөөгүй, гүйлгээ хийсэн байна.
13. ОНТХО-аар 2015-2019 онд хэрэгжүүлсэн 1,684.1 сая төгрөгийн өртөгтэй 16 ТАХ-ны ажлын чанар байдал муу, эвдэрч гэмтсэн, 61.0 сая төгрөгийн 3 ТАХ-г Прокурорт шилжүүлсэн, тайлант онд хэрэгжсэн 145.7 сая төгрөгийн 3 ТАХ-ны ажлын чанар байдал муу, зураг төсөвгүй, зөрүүтэй хийгддэг зөрчлүүд гарсаар байгаа нь



захиалагчийн хяналт нэр төдий үр дүнгүй хийдэг, шат шатны ажлын хариуцлага сул байгааг харуулж байна.

14. Аудитад иргэдийн бүлгийн гүйцэтгэх 19.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хүүхдийн паркийн тоглоомын тоог нэмэгдүүлэх ажил, "Эл Эй ай Ди групп" ХХК, Барнаб ХХК-ийн гүйцэтгэсэн 55.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цэнгэлдэх хүрээлэнгийн төсөл боловсруулах, геологийн дүгнэлт гаргах ажлын баримт материалыг хамруулаагүй.

Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилтийн талаар:

15. "Алтайн хүрд" ХХК-ний гүйцэтгэсэн 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Алтай хотоор дайран өнгөрч байгаа улсын чанартай автозамын гэрэлтүүлгийг туузан гэрлээр чимэглэх ажлын гүйцэтгэлтэй танилцахад туузан гэрэл зарим хэсгээрээ унжсан, асахгүй, гэрэлт самбар эвдэрсэн.
16. "Хайчийн нуруу" ХХК-ний гүйцэтгэсэн 39.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Алтай хотод нийтийн бие засах газрын байгууламжаас 70 жилийн цэцэрлэгт хүрээлэнгийн ариун цэврийн байгууламжийн гадна хаалга түгжээ хийгдээгүй, цахилгааны утсыг далдлаагүй, эмэгтэй суултуур 1 ш суурилуулаагүй, гадна довжооны ирмэг хагарсан, дээврийн төмрийн хормой хэсэг унасан байна.
17. Иргэдийн бүлгийн гүйцэтгэх 19.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хүүхдийн паркийн тоглоомын тоог нэмэгдүүлэх ажил хийгдээгүй байна.
18. Бумбат даваа ХХК-ний гүйцэтгэсэн Алтай хотод 3.49 км хатуу хучилттай авто зам, явган зам, дугуйн зам барих ажилтай танилцахад Баяншанд багийн авто зам хөндлөн цууралт үүсэж хагарсан, явган хүний зам зарим хэсэгтээ эвдэрч нурсан, Баянхайрхан багийн зам хагарсан, эвдрэл үүссэн байна.
19. "Орон нутгийн замын сангийн 2012-2014 оны хөрөнгө оруулалт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар "Заавар" ХХК-ийн 2013 онд "Алтай хотын хатуу хучилттай төв замуудад хурд сааруулагч хийх" ТАХ-д гэрээний дагуу тогтоосон 8.0 сая төгрөгийн алданги, "Орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар Алтай, Баян-Уул, Бигэр, Тайшир, Жаргалан, Хөхморьт, Цогт, Шарга сумдын "Жишиг гудамж бий болгох" ТАХ-нд тогтоосон 155.4 сая төгрөгийн алдангийг тус тус төлүүлээгүй, ямар нэгэн арга хэмжээ авч ажиллахгүй байна.



Дээрх дүгнэлтэд үндэслээд дараах шийдвэрийг гаргаж байна.

Албан шаардлага: Аймгийн ИТХ-ын дарга Д.Даваадорж:

1. Аймгийн нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, ТЭЗҮ, зураг төсөв, ажлын даалгаваргүй, төсөвт нөлөөлөх ачаалал, техникийн нөхцөлгүй ТАХ-г аймгийн ИТХ-аар батлахгүй байх.

Албан шаардлага: Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар, ЗДТГ-ын дарга Ц.Батзориг, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ж.Мөнхцэцэг, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн Д.Наранбадрах нарт

1. Аудитад баримт материал хамруулаагүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох
2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд мөрдөгдөх хууль эрх зүйг бүрэн мөрдөж, холбогдох албан тушаалтны сахилга хариуцлагыг чангатган арга хэмжээ авч, илэрсэн зөрчлийг арилга арга хэмжээг авч ажиллах
3. Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллага болох ГХБХБГ-аас хэрэгжүүлж байгаа хяналтыг үр дүнтэй, үр нөлөөтэй болгоход анхаарч ажиллах
4. Өмнөх онуудад хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудын чанар, ашиглалтын байдалд үнэлэлт өгч, хяналт тавьж ажиллах
5. Өмнөх шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахаар бодитой арга хэмжээ авч ажиллах

Зөвлөмж: Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар

1. Шилэн дансны тухай хууль, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах



Холбогдох байгууллагын санал:


ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

82093 Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жинст баг
Утас: 7048-4004, Факс: 7048-3360

2021.06.28 № 11700
танай 2021.06.28 ны № 323 -Т

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”, “Орон нутгийн өмчит дулааны станцуудын үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд санал байхгүй болно. Аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллана.


О.АМГАЛАНБААТАР

0205000633